

МОНГОЛЫН БАГШ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

Б.Жадамба, Чү.Байгалмаа, МУБИС

Abstract

This paper presents the findings on evaluating the changes of Mongolian state policies that have been implemented during the formation and developmental process of formal teacher education system in Mongolia. The paper reveals that the state policy on teacher education is not objective or scientific and based on subjectivity. In addition, it was developed without consideration of national tradition and culture. The above mentioned finding shows the evidence that our state policy documents on teacher education have adopted the ideologies and approaches from other countries. It has been observed that the state policy on teacher education has recently improved. For instance, the policy has elaborated the requirement for teachers and has been based on the traditions and culture of Mongolia.

This study focuses on how the implementation of requirements for teachers has changed since the people's revolution in 1921 till present. For this study, we have analyzed the requirements for teachers' quality in preschool, primary and secondary education sectors. We have applied the historical and systematic methodological approaches in order to revise the literature on the changes in teaching policy. As well as, we have found that requirements for teachers have been improved for last 100 years. We revised the documents such as The Constitutions of Mongolia dated back to 1924, 1940, 1960 and 1992 and laws on education of 1963, 1982, 1991, 1995 and 2002 to reveal the state policies on teachers. The State Policies on teacher education of the 1995 and 2014 were revised. The legal acts and regulations on education approved by the Government and the Parliament and project reports were analyzed. The quality of teaching staff depends on the reputation of the teaching profession in the society, social status of teachers and welfare system for teachers.

Түлхүүр үг

Эрдэм соёл, элдэв ухааны эрдэм, соёл боловсрол, боловсрох эрх, социалист соёл боловсрол, сурч боловсрох эрх

Үндэслэл

Даяаршил, МХТ-ийн эрчимтэй хөгжлийн өнөө үед багш боловсролын бодлогыг тогтворшуулан хөгжүүлэхдээ үндэсний уламжлалыг ХХI зууны шинэчлэлтэй хоршуулан НЭГЭН болж төгс зохицолдуулах хэрэгцээ шаардлага тулгамдаж байгаа нь энэ ажлыг гүйцэтгэх үндэслэл болж байна.

Төрөөс багш боловсролын талаар баримталж ирсэн бодлогын баримтуудад шинжилгээ хийж, тэдгээрийн өөрчлөлтөд хамаарах мэдээлэл цуглуулан, чанарын боловсруулалт шинжилгээ хийж хувьслын дүр төрхийг илрүүлсэн үр дүнгээ хэлэлцүүлэх энэхүү бичил судалгааны зорилго байлаа.

Судлагдахуун

Бодлогын баримт бичигт бид МУ-ын 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 1963,

1982, 1991, 1995, 2002 оны Боловсролын тухай хуулиуд, 1995, 2015 оны Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого болон багш боловсролд холбогдох УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө болон эрхзүйн бусад акт баримтууд, төслийн тайлан зэрэг эх материал нь зэргийг судалсан.

Судалгааны арга


Дээрх бодлогын баримт бичигт задлан шинжлэхүйн, нэгтгэн дүгнэхүйн, логик зүйн зэрэг судалгааны аргыг хэрэгжүүлж, мэдээ баримт цуглуулан, тэдгээрт чанарын шинжилгээ хийсэн үр дүнг дараах байдлаар томъёолж та бүхэнд хэлэлцүүлж байна.

* ✉ jadambaabadrakh@msue.edu.mn

Судалгааны баримт, үр дүн

Зураг 1

Багш боловсролын бодлогын хувьслын дүр төрх



Хүснэгт 1

Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх бодлогын хувьсал

Үе	Багш бэлтгэх бодлого, түүний хэрэгжилт		Багшийн мэргэжил дээшлүүлэх бодлого, түүний хэрэгжилт	
	Бодлого	Хэрэгжилт	Бодлого	Хэрэгжилт
1921-1924	Бичиг үсгийн багш: сурах төлөвтэй, чанар сайтай, бие махбодь эрүүл байх	Бичиг үсэг мэдэх идэр насны хүмүүсийг 4 сарын курсээр бэлтгэсэн. (ЗГ-ийн Газрын шийдвэр, (1922) Багш нарыг бэлтгэх тухай, № 135)	1924 Дотоод болон гадаадад мэргэжил дээшлүүлэх	Зун ... багшийг давтан сургаж боловсруулах, гадаадад үлэмжхэнийг боловсруулах (АГЯ-ны илтгэл., (1924) Багш нарыг давтан боловсруулах тухай)
1924 - 1940	Ерөнхий ухааны дунд зэргийн боловсролтой, олон төрлийн гэгээрэл боловсролын: бага сургууль цэцэрлэгийн, бичиг үсгийн багш бэлтгэх (БНМАУ-ын СнЗ., 1924 Багш нарыг бэлтгэх сургуулийн программ /монгол бичгээр/ 133 х)	Жинхэнэ олон ардыг эрдэм соёлд (БНМАУ-ын бага хурал., 1924 БНМАУ-ын үндсэн хууль) гэгээрүүлж, элдэв ухааны эрдэмд боловсруулах “Багш нарыг бэлтгэх сургууль” болгож 3 жил сургах (ЗГ-ын тогтоол., 1928 №7) Бага ангийн багшид Монгол бичгийн үсгийн дүрэм, элдэв ухааныг сургах	-Боловсронгуй багш нартай болох -Багш нарт боловсронгуй чадвартай этгээдийг олж хэрэглэх зэргээр чанарыг сайжруулбаас зохино. (МУБИС., 2011 Зуун өртөөлсөн нэгэн жаран)	“...Боловсронгуй багш дутагдан тул багшийн сургуулийн орон тоог нэмэгдүүлэх, түр сургууль байгуулах, .. чөлөөг тохиолдуулан багшийг давтан ... боловсруулах ... явдлыг түргэвчлэн сайжруулвал зохино” БНМАУ-ын Их Хурал (1929) Ардын гэгээрүүлэх хэргийн тухай тогтоол, 5-р сарын 1 сарын 14 өдөр

1940- 1960	<p>-Боловсролтой, улс төрийн мэдлэгтэй, заах аргын чадвартай багш бэлтгэх</p> <p>-Дээд боловсролтой багш бэлтгэх</p>	<p>-Бага сургуулийг дээд боловсролтой багшаар ханган, политехник боловсрол, үзэл суртал онол, сурган хүмүүжүүлэх чадварт давтан сургах</p> <p>-Багшийн үүрэг өндөржсөн тул тогтвортой ажиллуулах, байдлыг сайжруулах. (БНМАУ., 1963, Боловсролын тухай хууль, 21 дүгээр зүйл), 1966 онд ЕБС багшийн 97% дээд боловсролтой болсон. (Шагдар Ш., 2009 Монголын боловсролын түүх I боть)</p>	<p>-Багшийн чанарт анхаарч 7 жилийн боловсрол эзэмшүүлэх,</p> <p>-Багшийн мэргэжлийг тогтмол дээшлүүлэх</p> <p>-Багшийн чанарыг сайжруулах талаар арга хэмжээг авч хэрэгжүүлж</p>	<p>-Багш тоо нэмэгдсэн ч ... улс төрийн мэдлэг, заах арга сул учир курсийн багшийг 2-3 жилд 7 жилийн боловсролтой болгох (МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчдийн хурлын тогтоол (1943) Багш нарын мэргэжил дээшлүүлэх тухай)</p> <p>-АГЯ-нд Багшийн мэргэжил дээшлүүлэх тасаг, хэвлэл, номын сантай болгох (СнЗ ба МАХН-ын ТХ-ны тогтоол 1946, №41/17) -Багш гэрээр суралцах сектор байгуулах (МАХН-ын ТХ-ны тогтоол, 1949, №56/105) мэргэжил дээшлүүлэх институт байгуулагдсан.</p>
1960 – 1991	<p>-Сургалтыг амьдрал практиктай холбогч багш бэлтгэх</p>	<p>Багшийг дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулиар бэлтгэнэ. Эрдмийн зэрэгтэй багшийг дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллагын аспирантураар бэлтгэнэ. (БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол, 1956 №10)</p>	<p>-Мэргэжил дээшлүүлэх ...тогтолцоо бүрдүүлэх (БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол, 1969, №176)</p> <p>-Багшийн бүтээлч санаачилгыг хөгжүүлэх ... аттестатчиллыг тогтмол явуулна (БНМАУ., 1982 Боловсролын тухай хууль)</p>	<p>-Багшийн мэргэжлийг Эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжил дээшлүүлэх институт, курс, үйлдвэрлэлд дээшлүүлж, ... өөрийн болон ЗХУ бусад социалист орны сурган хүмүүжүүлэх ухааны ололтыг нэвтрүүлнэ. (БНМАУ.,1982 Боловсролын тухай хууль)</p>
1991 – хойш	<p>-Сурган хүмүүжүүлэх дээд боловсролтой багш (БНМАУ., (1991) Боловсролын тухай хууль).</p> <p>-Мэргэжлийн сургуулийн багшийг Монгол улсын их сургуулиар, ЕБС-н багшийг ИС, коллежоор, ИДС-ийн багшийг ... шинжлэх ухаан өндөр хөгжсөн оронд бэлдэнэ.</p> <p>(БНМАУ-ын хууль, (1991) Боловсролын тухай хууль)</p> <p>Багшийн сурган хүмүүжүүлэх ур чадвар, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх</p> <p>(УИХ 1995 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого)</p> <p>Багш багшлах эрхтэй. (УИХ 2002 Боловсролын тухай хууль) ЕБС-д магистр багш 70% хүргэх (УИХ-ын тогтоол., 2015 №12)</p>	<p>IX-X ангид багш төрөлжсөн сургалт нээж, төгсөгчдөөс нь багш бэлтгэх ИДС-д элсүүлэх. Багшийг...дан мэргэжлээр бэлтгэх. Коллеж төгсөгч I-IV анги, ИС төгсөгч I-X ангид хичээл заах (БНМАУ-ын хууль, 1991 Боловсролын тухай хууль,)</p> <p>-Багшид зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох;</p> <p>-ЕБС-д бакалавр; ИДС, коллежид магистраас доошгүй багш (УИХ., 1995, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого)</p> <p>-Багшийн ур чадвар, нэр хүнд, ёсзүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлж, ажлыг нь бодитой үнэлэх.</p>	<p>Дунд боловсролтой багшийг (3-5 жилд) дээд боловсролтой болгох</p> <p>-Багшийн мэргэжилд дээшлүүлэх зардлыг 2007 оноос 6 дахин нэмэгдүүлж, жил бүр 10%-с доошгүй өсгөх (2008, №12)</p> <p>БШУС-ын 2012 оны А/136 тушаал</p> <p>“Багшийн хөгжил” хөтөлбөр.</p> <p>(ЗГ-ын 2014 оны 71 тогтоол) “Тэргүүлэх мэргэжлийн жагсаалт”-д тусгай хэрэгцээт боловсрол, хүүхдийн хөгжил судлал, сургалтын технологи, арга зүй</p>	<p>Багш мэргэжлээ байнга дээшлүүлэх. монгол бичиг, гадаад хэл, компьютерийн (УИХ-ын тогтоол, 2002, Боловсролын тухай хууль)-мэргэжлийн зэрэг олгох. -БМДС-ыг төвлөрсөн, бүсчилсэн, зайн хэлбэрээр зохион байгуулах. Хөдөөг хангах, тогтвортой ба г ш л у л а х ы н . . . т у л д захиалга, гэрээгээр бэлтгэх, багш нарт хос мэргэжил эзэмшүүлэх (ЗГ-ын тогтоол 20148 №71)</p> <p>Элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо төлбөрийн 70%-ийг, 751-с дээш 100% төлбөрөөс чөлөөлнө. Математик байгалийн ухаан, дуу хөгжмийн багш 600-аас дээш, “Багш бага, Сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжлээр 550-аас дээш оноотой эрэгтэй элсэгчид төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно. (МУБИС-ийн захирлын тушаал, 2017 Оюутан элсүүлэх тухай, № 72)</p>

Ардын хувьсгалын эхний жилүүдэд багшид тавигдаж байсан шаардлага нь сурах төлөвтэй, чанар сайтай, эрүүл, идэр залуу гэж байсан бол 1940-өөд оны үед элдэв ухааны эрдэм, чанарыг эрхэмлэж, 1950-иад оноос хойш сурган хүмүүжүүлэх дээд боловсролтой багшийг багшлуулах төдийгүй багшийн мэргэжлийг тогтмол дээшлүүлэх тухай, 1960-аад оноос хойш сургалтыг амьдрал практиктай холбох багшийн бүтээлч санаачилгыг дэмжих, 1990-өөд оноос хойш багшийн ёс зүй, мэргэжлийн чадварыг эрхэмлэсэн бодлогыг тухай бүр хэрэгжүүлсээр иржээ. Эдгээр бодлогууд нь тухайн үеийн багш нар, тэдний мэргэжлийг дээшлүүлэх талаар бодит ажил хэрэг болон хэрэгжиж, үр дүнгээ өгсөн нь илэрхий байна.

Хэлэлцүүлэг

Нэгэн зүйл: Монгол улсын орчин цагийн багш боловсролын бодлого “бичиг үсгийн багш бэлтгэх”-ээс эхлэн багшийг ЮНЕСКО-гийн удирдамж, бусад улс орны жишигт хүрэхүйц болж хувьсан өөрчлөгдөж боловсронгуй болсоор ирснийг баримтууд нотолж байна.

Нэгэн зүйл: 1921–1924 оны үеийн багш боловсролын хүрээн дэх багшийн загвар нь “бичиг үсэг заах чадвар+багш бие хүний чадвар” гэсэн хэлбэртэй байжээ. (Хүснэгт 1)

Нэгэн зүйл: 1924–1940 оны хооронд багш боловсролын бодлогын суурь нь “багшилж багш болох ухаан” байсан байна. Үүнийг ардын зохиолч Ш. Сүрэнжавын “Багш” найраглалын “...ахмад үеийн багш нарт хийхгүй ажил гэж байгаагүй ...хувьсгалт соёлыг дэлгэрүүлнэ гээд шамдаж явсан цаг тэднийх... ..шинэ үеийн багш нарт шимтэхгүй эрдэм гэж байхгүй, шинэ үеийн багш нарт шамдахгүй цаг гэж байхгүй...” зэрэг мөртүүд гэрчилж байна.

Нэгэн зүйл: 1940–1960 оны хооронд багш боловсролын хөгжил “багш болж багшлах ухаан”-нд суурилан, уламжлалт соёлоосоо хөндийрч, улс төрийн агуулгатай хөгжиж эхэлсэн байна. Үүнийг 1 дүгээр хүснэгт дэх “боловсронгуй багш нартай болох”, “..улс төрийн мэдлэгтэй”, “дээд боловсролтой багш бэлтгэх”, “үзэл суртал, онол”, “соёл боловсрол”, “хувьсгалын анхан шатны ЕБС” зэрэг түлхүүр үгс гэрчилж байна.

Нэгэн зүйл: 1960–1991 оны хооронд багш боловсролын бодлого “сургалтыг практиктай холбогч, бүтээлч санаачилгатай багш бэлтгэх” -д чиглэн багш боловсролын иж бүрэн тогтолцоог бүрдүүлж чадсан байна.


Нэгэн зүйл: 1991 оноос өнөөг хүртэл багш боловсролын бодлого ЮНЕСКО-гийн удирдамж,

олон улсын багш боловсролын жишгийн дагуу багшийг “ҮЙЛ–багш мэргэжлийн чадамж–багш бие хүний чадамж” гэсэн загварын хүрээнд бэлтгэх, мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

Багшид тавигдах шаардлагын өөрчлөлтүүд нь бичиг үсгийн эрдэмтэй, тусгай дунд болон СХ-лэх дээд боловсролтой, бакалавр, магистр, тогтвортой хөгжихүйц боловсролтой, хүүхэд бүрийг хөгжүүлэгч багш, ХХI зууны багш, эрдмийн зэрэгтэй гэж тасралтгүй дээшилж өндөрссөөр иржээ. Үүнтэй уялдуулан багш мэргэжлээр элсэгчдэд ч тавигдаж шаардлага мөн адил өндөрссөөр ирсэн нь дараах зургаас харагдана.

Зураг 2

Багш мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлага



1923 онд багш бэлтгэх түр курст элсэгчдэд бичиг үсэг мэдэх залуу насны хүмүүс, сурах төлөвтэй, бие эрүүл гэснээс эхлээд дараа нь 7 болон 8 дугаар анги төгссөн, 10 дугаар анги төгссөн, 12 дугаар анги төгссөн зэрэг шаардлага тухай бүр тавигдаж хэрэгжсээр ирсэн байна.

Зураг 3

Аргагүйн өөрчлөлт




Хүснэгт 2

ЮНЕСКО-ийн зөвлөмжийн (...багшлах боловсон хүчний статусын тухай, 1997) шинжилгээ

Гурвал бүтцийн бүрдүүлбэр	Амь	Ахуй	Ухамсар
Амин чанар	Үйл ажиллагаа	Завч сургах аргагүй	Судлан шинжлэх ур чадвар
Ахуй чанар	Нийгмийн баталгаа	Ачаалал	Статус
Мөн чанар	Есзүй	Харилцаа	Хариуцлага

Багшийн чанарыг амин, ахуй, мөн чанарын гурвал үүднээс тайлбарлавал түүний амин чанар нь үйл ажиллагаа, ахуй чанар нь заан сурган аргагүй, ухамсарт чанар нь судлан шинжлэх ур чадвар юм. Багшийн амь ухааны гурвал нь үйл ажиллагаа, нийгмийн баталгаа, мэргэжлийн ёсзүй байна. Харин ахуй ухааны гурвал нь сургах аргагүй, ажлын ачаалал, харилцаа байна. Ухамсар чанарын гурвал нь судлан шинжлэх ур чадвар, багшийн статус хариуцлага байгаа нь бидний шинжилгээнээс харагдлаа. Иймд цаашид багш боловсролын уламжлал шинэчлэлийг хослуулан ном журамтай, ёс эрдэмтэй хөгжүүлэх хэрэгтэй байна.

Зураг 4
Багшийн нэгэн загвар



Дүгнэлт

Орчин цагийн Монгол улсад багш мэргэжил үүсч, багш бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх ажилд тавигдах шаардлага тасралтгүй өндөрсөж боловсронгуй болсоор Монгол уламжлал соёлдоо ойртох хандлагатай байна.

Багшийн талаар баримтлах төрийн бодлогууд нь судалгаанд суурилаггүй, хэрэгжилтэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн тооцоо хангалтгүй, залгамж чанар буюу уламжлал шинэчлэлийн уялдаа сул, байгууллагын хийгээд хүний хүчин зүйлсийг төдийлэн харгалздаггүй, сонирхолын бүлгүүдтэй зөвшилцдөггүй зэрэг байдал ажиглагдаж байна.

Цаашид багшийн талаар баримтлах төрийн бодлого боловсруулахад боловсролын удирдлагын тогтолцоо тохирох эсэх, хэрэгжүүлэх байгууллагын хийгээд хүний нөөц, санхүүгийн эх үүсвэр, улс төрийн болон Засгийн газар ба холбогдох сонирхлын бүлгүүд зөвшилцөл, уламжлал шинэчлэлийн зохицол зэргийг зайлшгүй харгалзах шаардлагатай.

Багшийн талаар баримтлах бодлогыг улс орны хөгжлийн нөхцөл байдал, хүн ам зүйн

төлөв, нийгмийн шаардлага, иргэдийн хэрэгцээг тодорхойлсон суурь судалгааны баримт нотолгоонд суурилан боловсруулж өргөн хүрээг хамарсан мэргэжлийн хэлэлцүүлгийн үр дүнд тусган сайжруулах нь зүйтэй юм.

Ашигласан материал

- Ардын Гэгээрлийн Яам. (1924). Ардын Гэгээрлийн Яамны илтгэл. Улаанбаатар
- Ардын Засгийн газар. (1928). Ардын Засгийн газрын VII хурлын тогтоол. Улаанбаатар
- Ардын Засгийн газар. (1929 он 1 сарын 14). Ардын гэгээрүүлэх хэргийн тухай тогтоол. Улаанбаатар
- Ардын Их Хурал. (1960 он 7 сарын 06) БНМАУ-ын Үндсэн хууль. Улаанбаатар
- Монгол Улсын засгийн газар. (2002 он 05 сарын 03). Бага дунд боловсролын тухай хууль. Улаанбаатар
- Ардын Гэгээрлийн Яам. (1924). Багш нарыг бэлтгэх сургуулийн программ /монгол бичгээр/, 133 дугаар тал. Улаанбаатар
- Ардын Их Хурал. (1992 он 01 сарын 13). Монгол улсын үндсэн хууль. Улаанбаатар
- Ардын Их Хурал. (1963 он 02 сарын 09). БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол. Сургууль амьдралын холбоог бэхжүүлж, ардын боловсролыг цаашид хөгжүүлэх тухай. Улаанбаатар
- Ардын Их Хурал. (1982 он 12 сарын 09). БНМАУ-ын Ардын боловсролын хууль. Улаанбаатар
- Ардын Их Хурал. (1991 он 07 сарын 16). БНМАУ-ын Боловсролын хууль. Улаанбаатар
- Сайд нарын Зөвлөл. (1956). БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл-ийн 10-р тогтоол. Улаанбаатар
- Сайд нарын Зөвлөл. (1969). БНМАУ-ын СнЗ-ийн 176 дугаар тогтоол. Улаанбаатар
- Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам. (2012 он 11 сарын 22) БСШУС-ын тушаал. Дугаар А/136, I хавсралт. “Багшийн хөгжил” хөтөлбөр. Улаанбаатар
- Монгол Улсын Их Хурал. (2002 он 05 сарын 03). Боловсролын тухай хууль. Улаанбаатар
- Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2012). БСШУЯ-ны захиалгат төслийн тайлан. Монголын ИДСК-ийн багшийн хөгжлийн өнөөгийн байдал. Улаанбаатар
- Монгол Улсын Засгийн Газар. (2014 он 03 сарын 07). ЗГ-ын 71 дүгээр тогтоолын I хавсралт. “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох тухай”. Улаанбаатар
- Төлөөлөгчдийн Хурал. (1949). МАХН-ын ТХ-ны 56/№105 тогтоол. Улаанбаатар

- Төлөөлөгчдийн Хурал. (1943). МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчдийн хурлын тогтоол. “Багш нарын Мэргэжил дээшлүүлэх тухай”. Улаанбаатар
- Монгол Улсын Засгийн Газар. (1995 он 06 сарын 13). Монгол улсын хууль. Боловсролын тухай. Улаанбаатар
- Монгол Улсын Их Хурал. (2008). Монгол Улсын Их Хурлын 12-р тогтоол. Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. *Улаанбаатар*
- Монгол Улсын Их Хурал. (1995). Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. Улаанбаатар
- Монгол Улсын Дотоод Яам. (1923.03.29). МУ-ын Дотоод яамны шийдвэр, Ардын Засгийн 135 тоот шийдвэр. Улаанбаатар
- Монгол Улсын Их Хурал. (2015). МУ-ын ИХ-ын 12 дугаар тогтоолын хавсралт. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/. Улаанбаатар
- Улсын 5-р Их Хурал. (1924 он 11 сарын 26). Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхдугаар Үндсэн хууль. Улаанбаатар
- Улсын 8-р Их Хурал. (1940 он 6 сарын 30). БНМАУ-ын Үндсэн хууль. Улаанбаатар
- Сайд нарын Зөвлөл. (1946). СнЗ ба МАХН-ын ТХ-ны хамтарсан хурлын 41/17 тогтоол. Улаанбаатар
- Ардын Боловсролын Яам. (1967). Хувьсгалын ардчилсан шатны ерөнхий боловсролын сургууль. 1921-1940. 16 х. Улаанбаатар
- Шагдар, Ш. (2009). Монголын боловсролын түүх. Улаанбаатар
- Шагдар Ш., Дашхүү Д., (1982). Багшлах боловсон хүчнийг бэлтгэх ба хэрэгцээг тодорхойлох үндэслэлийг сайжруулах асуудалд. Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл №6, 79-89 дүгээр тал. Улаанбаатар
- UNESCO Bangkok Asia and Pacific Regional Bureau for education, (2013) Handbook on Education Policy Analysis and programming
- Korean Educational Development Institute (2009) Teacher Policy; Procurement and Disposition of Qualitative Teachers